



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/17/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа.....	12
3.5.4 Бараа материал.....	12
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	13
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.7 Өр төлбөр.....	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/229
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчид нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан.

Төв аймгийн Дэлгэрхаан суманд 2022 онд улс, аймаг, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгө оруулалтаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын шинэчлэл инженерийн дэд бүтцийн ажил 4,000,000.0 мянган төгрөгийн ажил эхэлсэн, аймгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн цэвэр усан хангамжийн даралтад цамхагт худаг 185,575.0 мянган төгрөг, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн 27,000.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын орон сууц 100,000.0 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүн өрмийн худаг 30,000.0 мянган төгрөг, халуун ус, саун, үсчин, хивс угаалгын газрын барилгын засвар тоног төхөөрөмж 176,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 60,000.0 мянган төгрөг, ковш машин худалдан авахад 60,000.0 мянган төгрөг, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 19,900.0 мянган төгрөг, хогийн цэгийг булшлах цэвэрлэх шатаах ажил 19,000.0 мянган төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар Тэрбум мод, Ногоон сум 32,850.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Орон нутгийн төсөвт 2022 онд татварын орлого 277,775.3 мянган төгрөг, татварын бус орлого 590,570.0 мянган төгрөг, нийт 868,345.3 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 52,346.3 мянган төгрөгөөр буюу 106,0 хувь биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр задалбал нэгдсэн дүнгээрээ тасарсан нь суутган-2 үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичгээр өгсөн заавар чиглэлийн дагуу орон нутгийн улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 6,668,866.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 566,174.5 мянган төгрөгийн бараа материал, 13,556.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 144,572.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		706,100.3	1,220,394.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	215,855.0	680,398.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	263,840.6	356,381.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	226,404.6	183,614.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,584,910.6	1,176,788.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,584,910.6	1,176,788.7
39200	Биет хөрөнгө		4,564,008.6	1,175,824.7
39300	Биет бус хөрөнгө	13	20,902.0	964.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,291,010.8	2,397,182.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		29,928.2	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	29,928.2	0.0
41300	Өглөг	17а, 17б	29,928.2	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,261,082.6	2,397,182.7
51	Засгийн газрын хувь оролцоо		5,261,082.6	2,397,182.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,624,609.5	579,464.8
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,624,609.5	579,464.8
51200	Хуримтлагдсан үр дүн		1,653,746.1	1,506,702.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,982,726.9	311,015.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,291,010.8	2,397,182.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,720,447.6	3,709,739.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		231,778.3	1,009,116.2
110	Орлогын албан татвар		34,212.0	219,549.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		34,212.0	225,295.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-	5,745.6
113	Хөрөнгийн албан татвар		356.0	26,856.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		197,210.3	762,710.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,725,739.9	566,927.8
120	Нийтлэг татварын бус орлого		1,725,739.9	566,927.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,762,929.4	2,133,695.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,975,974.7	2,683,190.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,975,974.7	2,683,190.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,163,038.1	1,167,872.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,136,486.4	276,356.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		153,518.4	39,552.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		295,800.5	328,269.0
2104	Хангамж, бараа материалын зардал		56,527.0	211,601.6
2105	Нормативт зардал		127,636.5	33,362.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,235.0	25,980.0
2107	Томилолт, зочны зардал		7,309.8	3,099.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		51,673.6	79,026.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		328,850.9	170,624.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		812,936.6	1,515,317.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,744,472.9	1,026,549.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		156,071.1	3,912,782.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,588,401.9	2,886,233.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,076,090.1	3,158,814.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	231,778.3	919,803.2
110	Орлогын албан татвар	34,212.0	130,236.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	34,212.0	135,982.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-5,745.6
113	Хөрөнгийн албан татвар	356.0	26,856.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	197,210.3	762,710.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,855.7	4,162.0
1181	Газрын төлбөр	877.8	1,864.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	191,476.8	756,683.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,807.0	105,315.4
120	Нийтлэг татварын бус орлого	80,807.0	105,315.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,763,504.8	2,133,695.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,763,059.4	2,158,252.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,763,059.4	2,158,252.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,939,256.6	865,578.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,123,899.0	276,376.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,909.1	36,753.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	298,458.7	328,269.0
2104	Хангамж, бараа материалын зардал	53,779.2	24,447.4
2105	Нормативт зардал	106,200.4	63,146.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,372.4	25,980.0
2107	Томилолт, зочны зардал	7,709.8	3,099.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,719.9	34,462.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,208.1	73,043.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	823,802.8	1,292,674.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	313,030.7	1,000,561.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	136,965.0	499,918.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	136,965.0	499,918.4
2200	Дотоод эх үүсвэрээр	136,965.0	499,918.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-136,965.0	-499,918.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-22,557.0	-36,100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,557.0	36,100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	153,508.7	464,543.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	62,346.3	215,855.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,855.0	680,398.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,671,984.1	3,671,984.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	740.9	740.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,672,725.0	3,672,725.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-44.3	-44.3
9	Тайлант үеийн үр дүн	1,588,401.9	1,588,401.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,261,082.6	5,261,082.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,261,082.6	5,261,082.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,536.3	19,536.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,280,618.9	5,280,618.9
17	Өмчид гарсан өөрчилөлт	2,797.2	2,797.2
19	Тайлант үеийн үр дүн	-2,886,233.4	-2,886,233.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,397,182.7	2,397,182.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,049,014.2	1,332,497.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	860,924.0	822,138.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,229.2	782,443.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,334.4	276,376.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,861.7	36,753.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	347,647.4	328,269.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,475.4	23,475.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,750.0	29,240.0
2107	Томилолт, зочны зардал	3,099.5	3,099.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,994.8	34,162.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,066.0	51,067.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,694.8	39,694.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,694.8	39,694.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,033,606.3	474,258.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	154,483.9	36,100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,049,014.2	1,340,925.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	171,013.5	171,013.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,532,400.0	1,134,885.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	345,600.7	35,026.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	1,178.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	9,607.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,636.9	58,436.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,636.9	58,436.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,908.6	45,647.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	119.7	972.0
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,851.8	300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,937.1	44,375.8
211	ХҮҮ	-	-
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
212	ТАТААС	-	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,728.3	12,788.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,760.3	9,800.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,968.0	2,988.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	210,636.9	58,436.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,636.9	58,436.3
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн засаг даргын харьяа байгууллага юм.

Дэлгэрхаан сум аймгийн “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жилийн хүрээнд “Ногоон сум” төсөл хэрэгжүүлэн сумын хэмжээнд 3075 ширхэг мод ургуулан, хашаажуулсан бөгөөд урианы жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт 90,33 хувьтай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан суманд 2022 онд улс, аймаг, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгө оруулалтаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын шинэчлэл инженерийн дэд бүтцийн 4,000,000.0 мянган төгрөгийн ажил эхэлсэн, аймгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн цэвэр усан хангамжийн даралтад цамхагт худаг 185,575.0 мянган төгрөг, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн 27,000.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын орон сууц 100,000.0 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүн өрмийн худаг 30,000.0 мянган төгрөг, халуун ус, саун, үсчин, хивс угаалгын газрын барилгын засвар тоног төхөөрөмж 176,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 60,000.0 мянган төгрөг, ковш машин худалдан авахад 60,000.0 мянган төгрөг, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 19,900.0 мянган төгрөг, хогийн цэгийг булшлах цэвэрлэх шатаах ажил 19,000.0 мянган төгрөг, хувийн хөрөнгө оруулалтаар Тэрбум мод, Ногоон сум аяны хүрээнд 32,850.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ, Иргэнтэй орон нутгаас зохион байгуулж байгаа олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох талаар гэрээ байгуулан нийт 7 ААНБ-аас 3,600.0 мянган төгрөг авч, холбогдох үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 91,0 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Сумын ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01 тоот тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 98,23 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 тоот захирамжаар сумын дотоод хяналтын баг томилох тухай шийдвэр 7 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон байна. Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 8 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан байна. Сумын дотоод хяналт шалгалтын баг нь байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, анхан шатны баримтын хөтлөлт, бараа материалын зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэл, шилэн дансны хөтлөлтөд хяналт хийсэн боловч шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичгийг шалгахад баримт бичгийг батлаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сум нь Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,893,828.1 мянган төгрөгөөр буюу 54,7 хувиар буурсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд улсын төсвийн байгууллага руу шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	215,855.0	680,398.3	464,543.3
Авлага	263,840.6	356,381.5	92,540.9
Бараа материал	226,404.6	183,614.1	-42,790.5
Үндсэн хөрөнгө	4,584,910.6	1,176,788.7	-3,408,121.9
Нийт хөрөнгө	5,291,010.8	2,397,182.6	-2,893,828.2
Өр төлбөр	29,928.2	0.0	-29,928.2
Засгийн газрын хувь оролцоо	5,261,082.6	2,397,182.7	-2,863,899.9
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	5,291,010.8	2,397,182.7	-2,893,828.1

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 680,39.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 464,543.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЗДТГ-ын барилгын ажлын тендер зарлагдаагүй тул үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 356,381.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,540.6 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага, хүү дутуу бүртгэснийг нэмж бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 183,614.14 мянган төгрөг болж, өмнөх оноос 42,790.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 118,462.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,176,788.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,408,121.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 3,794,319.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 0.0 төгрөг болж, өмнөх оноос 29,928.2 мянган төгрөгөөр буурсан нь ОНХО 12,879.5 мянган төгрөг, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 16,672.9 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,397,182.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,863,899.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 680,398.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 464,543.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Банкинд байгаа бэлэн мөнгө	215,855.0	680,398.3	464,543.3
Төрийн сангийн харилцах	201,066.1	663,266.7	462,200.6
Арилжааны банк дахь харилцах	14,788.9	17,131.6	2,342.7
Дүн	215,855.0	680,398.3	464,543.3

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 663,266.7 мянган төгрөгийн 98,2 хувь буюу 651,509.4 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого, 1,4 хувь буюу 9,503.4 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сан, 0,3 хувь буюу 2,150.0 мянган төгрөг БНСБС-ийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 17,131.6 мянган төгрөгийн үлдэгдлийг Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна. Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэлд ЗДТГ-ын барилгын тендер зарлагдаагүйтэй холбоотой санхүүжилт хийгдээгүйгээс үлдэгдэлд нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг Татварын Е баримтын дүнтэй тулгалт хийхэд цахим төлбөрийн баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 324,437.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх зөвлөмж бичигдсэн.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 356,381.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,540.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Дансны авлага	263,840.6	356,381.5	92,540.9
Байгууллагаас авах авлага	10,944.9	7,778.3	-3,166.6
Хувь хүмүүсээс авах авлага	252,895.8	348,603.2	95,707.4
Дүн	263,840.7	356,381.5	92,540.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 35381.5 мянган төгрөгийн 97,8 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 2,2 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 93,3 хувь буюу 325,264.0 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 90,0 хувь буюу 7,778.3 мянган төгрөгийн авлага нь ЗДТГ-ын өвс, тэжээлийн авлагын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 356,381.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,540.6 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага, хүү дутуу бүртгэснийг нэмж бүртгэснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

Сумын ЗДТГ нь 2021 оны өвсний авлагын үлдэгдэл 7,000.0 мянган төгрөгийг Хүүлэй хааны хишиг ХХК-аас авч барагдуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 183,614.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,991.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Түүхий эд материал	40,930.4	33,362.4	-7,568.0
Тусгай зориулалттай материал	2,190.5		-2,190.5
Эм боох материал	38,739.9	33,362.4	-5,377.5
Хангамжийн материал	146,675.1	150,251.7	3,576.6
Бичиг хэргийн материал	3,448.8	85.0	-3,363.8
Аж ахуйн материал	114,139.7	30,533.5	-83,606.2
Сэлбэг хэрэгсэл	12,424.7	3,389.0	-9,035.7
Бусад хангамжийн материал	1,662.0	97,244.2	95,582.2
Мал амьтад	15,000.0	19,000.0	4,000.0
Дүн	187,605.6	183,614.1	-3,991.5

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 183,614.1 мянган төгрөгийн 81,3 хувийг ЗДТГ, 18,2 хувийг эмийн эргэлтийн сан, 0,5 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 183,614.14 мянган төгрөг болж, өмнөх оноос 42,790.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг,

Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 118,462.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,176,788.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,408,121.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Биет хөрөнгө	4,564,008.5	1,175,824.8	-3,388,183.7
Барилга, байгууламж, орон сууц	3,828,356.8	698,803.5	-3,129,553.3
Авто-тээврийн хэрэгсэл	45,930.0	72,482.1	26,552.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	162,817.8	37,299.9	-125,517.9
Зам, гүүрийн байгууламж	107,382.6	86,614.9	-20,767.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	118,282.8	12,513.0	-105,769.8
Бусад үндсэн хөрөнгө	288,304.5	268,111.4	-20,193.1
Ном	12,934.0		-12,934.0
Биет бус хөрөнгө	20,902.0	964.0	-19,938.0
Програм хангамж	600.0	525.0	-75.0
Бусад биет бус хөрөнгө	20,302.0	439.0	-19,863.0
Дүн	4,584,910.5	1,176,788.8	-3,408,121.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,84 хувь буюу 1,175,008.8 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,14 хувь буюу 1,692.9 мянган төгрөгийг ИТХ, 0,01 хувь буюу 87.0 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,176,788.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,408,121.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 3,794,319.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг болж, өмнөх оноос 29,928.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Өглөг	29,928.2	0.0	-29,928.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	425.0	0.0	-425.0
Байгууллагад төлөх өглөг	29,383.3	0.0	-29,383.3
Татварын өглөг /ТӨҮГ/	119.9	0.0	-119.9
Дүн	29,928.2	0.0	-29,928.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,397,182.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Засгийн газрын хувь оролцоо	5,261,082.6	2,397,182.7	-2,863,899.9
Засгийн газрын оруулсан капитал	1,624,609.5	579,464.8	-1,045,144.7
Хуримтлагдсан үр дүн	1,653,746.2	1,506,702.5	-147,043.7
Өмнөх үеийн үр дүн	65,344.3	4,392,935.9	4,327,591.6
Тайлант үеийн үр дүн	1,588,401.9	-2,886,233.4	-4,474,635.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,982,726.9	311,015.4	-1,671,711.5
Дүн	5,261,082.6	2,397,182.7	-2,863,899.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,397,182.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,863,899.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,094,840.8 мянган төгрөг, нийт зарлагыг 1,094,840.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 407,030.6 мянган төгрөгөөр нэмж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05 тоот тогтоолоор урсгал зардлыг 1,501,871.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ЗДТГ-ын хөрөнгийн зардлыг нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолоор ИТХ-ын ЗДТГ-ын хөрөнгийн зардлыг 637,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 868,345.3 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 664,054.7 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 191,116.8 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 171,013.6 мянган төгрөг, малын тоо толгойн татварын шилжих үлдэгдэл 33,876.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 154,483.9 мянган төгрөгийн нийт 2,049,014.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 470,830.5 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 664,054.7 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 171,013.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 35,026.7 мянган төгрөгийн нийт 1,340,925.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 708,088.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 154,483.9 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 35,026.7 мянган төгрөг бүрдүүлж 119,457.2 мянган төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 868,345.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 920,340.9 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 51,995.6 мянган төгрөгөөр буюу 105,99 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орлогыг нэр төрлөөр нь задалбал хөрөнгийн орлого 5,353.5 мянган төгрөг буюу 24,33 хувиар суутган 2 орлого 4,699.7 мянган төгрөг буюу 29,37 хувиар, Галт зэвсэгийн албан татвар 650.0 мянган төгрөг буюу 75,58 хувиар, малын тоо толгойн албан татвар 12,654.3 мянган төгрөг буюу 37,35 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 141.4 мянган төгрөг буюу 11,78 хувиар, газрын төлбөр 135,3 мянган төгрөг буюу 6,77 хувиар өөр тус тус тасарсан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын 2022 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 2,049,014.2 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 1,332,496.9 мянган төгрөг буюу 716,517.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 65,03 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 17,066.1 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 19,378.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 510.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 1,832.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 559,347.9 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 118,383.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн /70106 /	1,222,104.4	669,863.9	552,240.5	54.8
2	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн /70105/	94,864.5	94,265.8	598.7	99.4
3	Ерөнхий боловсрол хөтөлбөрийн /71802/	233,832.6	213,078.3	20,754.3	91.1
4	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн /71801/	43,899.2	42,059.3	1,839.9	95.8
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн /71602/	43,361.8	44,427.7	-1,065.9	102.5
6	Соёл урлаг хөтөлбөрийн /71702/	51,578.3	45,548.3	6,030.0	88.3
7	Орон нутгийн хөгжлийн сан	204,889.6	187,153.6	17,736.0	91.3
8	Хоршоо хөгжүүлэх сан	154,483.9	36,100.0	118,383.9	23.4
Нийт дүн		2,049,014.3	1,332,496.9	716,517.4	65.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн тайланд ИТХ-д 300.0 мянган төгрөг, ЗДТГ-т өвсний үнэ 2,679.5 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 434.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны үйл ажиллагааны үр дүнгээр шагнуулсан 2,000.0 мянган төгрөг, бэлчээрийн худаг гаргахад 12,000.0 мянган төгрөг, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн

албан хаагчдад олгох тэтгэмж 7,800.0 мянган төгрөг, малын гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх шатахууны зардалд 972.0 мянган төгрөг, ТАХ-ын орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт 29,850.0 мянган төгрөг, ХАА-н ээлжит тооллого явуулах шатахуун, таблет хүлээлцэх зардал, урамшуулал 2,364.8 мянган төгрөг, Ажил зуучлалын зардал 36.0 мянган төгрөг нийт 58,436.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас тээвэр шатахуунд 972.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 300.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 44,375.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 9,800.0 мянган төгрөг, 2,988.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлж 58,436.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 99.4 %	94,864.5	94,265.8
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98,6%	1,222,104.4	669,863.9
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100%	154,483.9	36,100.0
			ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн материал ирүүлээгүй байна.		
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 9 зорилт 31 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 67%, Хөтөлбөрийн хэрэгжилт 91.4%, “	233,832.6	213,078.3
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 14 зорилт 51 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 71.5 %	43,899.2	42,059.3
6	71702- Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 32 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97%	51,578.3	45,548.3

7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 2385 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд 364 иргэдийг хамруулна.	Нийт 8 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 2897 хүн, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 660/100%, артерийн даралтны эрт илрүүлэг 1119/100%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 362/91.1%, умайн хүзүүний эрт илрүүлэг 44/57.8% БЗДХ илрүүлэх 463/92.3%, элэгний В С илрүүлэгт 249/88.6% иргэн хамрагдаж нийт 88.3%. байна ЭМД-ын 4 багцын тусламж үйлчилгээний Өдрийн эмчилгээний багц- 46 иргэн Сэргээн засах эмчилгээний багц 73 иргэн гэрийн эргэлтийн багцад- 102 иргэн, Оношилгоо шинжилгээний багц 312 иргэн нийт 533 иргэн тус тус хамрагдсан	43,361.8	44,427.7
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 11 төслийг 204889.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 11, мөнгийг нь дутуу шилжүүлсэн 3 ажил байна. Хэрэгжилт 95.4%	204,889.6	187,153.6
Нийт дүн					2,049,014.3	1,332,496.9

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ЗДТГ-ын барилгын тендер зарлагдаагүй холбоотой хэрэгжилт 65,0 хувьтай байна .

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 2,049,014.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 30,735.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23,051.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллээс 18 шийдвэр буюу 46,737.5 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санал дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын дараагийн аудитаар хандивын орлого бүрдүүлэлтэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,051,117.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,051,117.9 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант оны үр дүнг нэгтгэлд орсон байгууллагын тайлант оны үр дүнтэй тулган шалгахад 296,205.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Өмнөх онд Орон нутгийн ерөнхий орлогын данс нь 12,879.5 мянган төгрөгийн өглөгтэй байсныг залруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Улсын төсөв рүү шилжсэн байгууллагуудын хаалтын балансыг давтан шалгахад 741,932.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 73,630.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 73,630.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Орон нутагт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 6 нэр төрөлд 26,542.5 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 41 дүгээр зүйлийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасны болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Төсвийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлж нэр төрлөөр бүрэн биелүүлэх талаар үр дүнд хүрч ажиллах

2.Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын хэлтсийн гаргасан мэдээ 920,691.6 мянган төгрөг, санхүүгийн нэгтгэсэн тайланд 920.341.0 мянган төгрөг буюу 350.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэж заасны болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Татварын болон татварын бус орлогын мэдээг орлогын дансны хуулганаас зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, мэдээний үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах

3.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

ОНХС-аас энгийн худаг сэргээн засварлах ажлын мөнгийг олгохдоо ХХОАТ 10 хувь суутгаж олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийг мөрдөж, Татварын хэлтэст татвар суутгаагүй орлого шилжүүлсэн тухай тайланг тухай бүр гаргаж өгч байх

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллээс 18 шийдвэр буюу 46,737.5 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, 2. ОНХС-тай холбоотой шилэн дансны хуулийн 6 дугаар

зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой 110.9 сая төгрөгийн 2 ажил мэдээлэх ёстой боловч мэдээлээгүй, 6.4.8-д заасны дагуу ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн ажилтай холбоотой 193,800.0 мянган төгрөгийн 11 шийдвэр, гэрээ мэдээлэх ёстой ч мэдээлэгдээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах тушаал, шийдвэрийн мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх, мэдээллийг бүрэн, ойлгомжтой мэдээлсэн эсэхэд дотоод хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга	3	1,051,017.9			3	1,051,017.9	3	1,051,017.9
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар	5	429,950.6			5	429,950.6	5	429,950.6
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	10,731.8			2	10,731.8	2	10,731.8
Дүн	10	1,491,700.3	-	-	10	1,491,700.3	10	1,491,700.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга	3	73,630.8					3	73,630.8
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар	1	7,000.0	1	7,000.0			-	-
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	940.0					1	940.0
Дүн	5	81,570.8	1	7,000.0	-	-	4	74,570.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга	1	46,737.5					1	46,737.5
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	304,759.6					1	304,759.6
Дүн	2	351,497.1					2	351,497.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар	1	324,437.2					1	324,437.2
Дүн	1	324,437.2					1	324,437.2
Нийт дүн	3	675,934.3					3	675,934.3